



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 2.1, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.2, 2.3, 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.2, 4.4.3, Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гадаадын иргэн, харьяатын газрын ёс зүйн хороог нэгдүгээр, Буянт-Ухаа дахь газрын ёс зүйн хороог хоёрдугаар, Дорноговь аймаг дахь газрын ёс зүйн хороог гуравдугаар, Хойд бүс дэх газрын ёс зүйн хороог дөрөвдүгээр, Зүүн бүс дэх газрын ёс зүйн хороог тавдугаар, Өмнөд бүс дэх газрын ёс зүйн хороог зургаадугаар, Баруун бүс дэх газрын ёс зүйн хороог долоодугаар хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Үйл ажиллагаандаа Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт, байгууллагын даргын 2017 оны А/15 дугаар тушаал, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, тогтоосон хугацаанд тайлан мэдээ гаргах, төрийн захиргааны ажилтны ёс зүйн дүрмийг сурталчлах, мэдээлэл хүргүүлэн ажиллахыг ёс зүйн хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨРӨН



**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ХОРОО**

- Дарга:** Харьяатын газрын ахлах мэргэжилтэн Ш.Мэндсайхан
- Нарийн бичиг:** Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Дуламжав
- Гишүүд:**
- Тамгын газрын тайлан, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Алтангэрэл
  - Виз, зөвшөөрлийн газрын виз, зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Ганчимэг
  - Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагч Б.Өнөмөнх
  - Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтэн Г.Ганбат
  - Боомт, орон нутгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Пүрэвсүрэн

